

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/003/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хушаат сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Э.Энхбүрэн
Утас: 70362442 Цахим хаяг: Enkhburene@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-6
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	7-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12-13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14-15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14-22
4. Аудитын тайлан	22
4.1 Ерөнхий зүйл.....	22
4.2 Материаллаг байдал.....	23
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24-25
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	25-26
5. Аудитын илрүүлэлт	26-28
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	29-30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХУШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ЗАХИРАХБААТАР ТАНАА

2025.03.25 № СЭА-2025/003/НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтын 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1-2.1.6 дахь заалтууд болон 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн

ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- **ЗДНХ**-ийн батлагдсан төсвөөс Хүдэр сумын харьяат Монгол Улсын начин Д.Төрболдын цолны мялаалгад **2,000.0** мянган төгрөгийн хандив өгч төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

ЗДТГ нь:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зургийг хадгалан үлдээх зорилгоор **3,377.4** мянган төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээт ажлыг хүлээж аваагүй,
- Шууд худалдан авах босго үнээс давсан **28,731.1** мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр НИК ХХК-иас шууд худалдан авсан,
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс **5,826.3** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон урамшууллаас хувь хүний орлогын албан татварын **2,285.5** мянган төгрөгийг суутгасан боловч холбогдох дансанд шилжүүлэлгүйгээр өр төлбөр үүсгэсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

Хушаат сумын ИТХ-ын "2024 оны тодотгосон төсвийг батлах тухай" 2024 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор татварын орлогыг 561,414.8 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 46,940.3 мянган төгрөгөөр, нийт төсвийн орлогыг 608,355.1 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 810,893.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 202,538.4 мянган төгрөгөөр буюу 29.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,470,325.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,133,224.5 мянган төгрөгийг зарцуулж, төсвийг 16.7 хувиар хэмнэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг "Хангалттай" гэж дүгнэсэн бөгөөд 2024 онд аймгийн "Тэргүүний сум"-аар шалгарсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	575,563.40	774,688.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	195,041.80	480,165.60
33	АВЛАГА	206,377.00	124,826.00
35	БАРАА МАТЕРИАЛ	174,144.60	169,696.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,231,862.40	1,760,796.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,231,862.40	1,760,796.20
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	1,114,979.60	1,638,545.40
39300	Биет бус хөрөнгө	116,882.80	122,250.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,807,425.80	2,535,484.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,998.65	6,560.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,998.65	6,560.00
41300	Өглөг	21,998.65	6,560.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,785,427.16	2,528,924.60
51	Засгийн газрын хувь оролцоо	1,785,427.16	2,528,924.60
51100	Засгийн газрын оруулсан капитал	310,470.40	310,470.40
51200	Хуримтлагдсан үр дүн	1,314,400.95	2,057,898.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,555.80	160,555.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,807,425.80	2,535,484.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,809,769.80	2,989,929.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	525,799.50	753,416.70
110	Орлогын албан татвар	231,720.00	404,092.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	248,947.40	431,028.50
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(17,227.40)	(26,935.90)
113	Хөрөнгийн албан татвар	210,586.80	229,559.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,492.70	119,764.70

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	321,457.00	683,320.30
120	Нийтлэг татварын бус орлого	321,457.00	683,320.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	962,513.20	1,553,192.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,403,291.28	1,765,417.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,189,879.89	1,604,774.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,161,643.64	1,558,958.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,529.90	662,314.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,456.50	83,447.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,739.35	374,754.80
2104	Хангамж, бараа материалын зардал	51,475.20	54,431.90
2105	Норматив зардал	0	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,976.10	90,288.00
2107	Томилолт, зочны зардал	6,035.60	7,566.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	335,974.63	127,613.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	196,456.40	158,543.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,236.20	45,815.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	213,411.40	160,643.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	406,478.51	1,224,512.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	242,707.20	481,015.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	163,771.34	743,497.40

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	/мянган төгрөгөөр/	
			Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,621,655.80	0	1,621,655.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,621,655.80	0	1,621,655.80

9	Тайлант үеийн үр дүн	163,771.30	0	163,771.30
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,785,427.20	0	1,785,427.20
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,785,427.20	0	1,785,427.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,785,427.20	0	1,785,427.20
19	Тайлант үеийн үр дүн	743,497.40	0	743,497.40
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,528,924.60	0	2,528,924.60

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,530,789.90	2,481,387.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	525,799.50	753,416.70
110	Орлогын албан татвар	231,720.00	404,092.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	248,947.40	431,028.50
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(17,227.40)	(26,935.90)
113	Хөрөнгийн албан татвар	210,586.80	229,559.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,492.70	119,764.70
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,477.40	12,912.70
1181	Газрын төлбөр	53,201.40	91,299.10
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	20,813.90	15,552.90
1183	Бусад татвар	0	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,627.10	138,528.00
120	Нийтлэг татварын бус орлого	40,627.10	138,528.00
121	Хөрөнгийн орлого	0	0
122	Тусламжийн орлого	0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	964,363.20	1,589,442.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	995,310.10	1,506,147.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	995,310.10	1,506,147.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	967,073.90	1,430,712.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,529.90	662,314.10

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,090.60	83,447.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,300.70	390,193.40
2104	Хангамж, бараа материалын зардал	51,306.00	54,431.90
2105	Норматив зардал	0	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,976.10	90,288.00
2107	Томилолт, зочны зардал	6,035.60	7,566.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	335,974.63	127,613.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,860.30	14,858.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,236.20	75,435.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	535,479.80	975,240.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	475,963.60	690,116.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	475,963.60	690,116.60
2200	Дотоод эх үүсвэрээр	475,963.60	690,116.60
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(475,963.60)	(690,116.60)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(102,000.00)	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	102,000.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(42,483.80)	285,123.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	237,525.60	195,041.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	195,041.80	480,165.60

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,470,325.10	2,133,225.56	(337,099.54)	86.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,612,090.20	1,491,567.00	(120,523.20)	92.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,565,036.10	1,445,751.82	(119,284.28)	92.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	728,998.30	661,931.35	(67,066.95)	90.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,095.90	83,447.49	(7,648.41)	91.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	394,204.50	390,193.45	(4,011.05)	98.98
2104	Хангамж, бараа материалын зардал	53,527.10	53,526.42	(0.68)	100.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	134,706.90	134,356.05	(350.85)	99.74
2107	Томилолт, зочны зардал	10,915.00	7,566.00	(3,349.00)	69.32
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,892.20	104,613.06	(23,279.14)	81.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,696.20	10,118.00	(13,578.20)	42.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,054.10	45,815.18	(1,238.92)	97.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,054.10	45,815.18	(1,238.92)	97.37
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	672,732.40	641,658.56	(31,073.84)	95.38
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	185,502.50	0.00	(185,502.50)	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,470,325.10	2,203,407.64	(266,917.46)	89.20
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,264,999.20	2,122,356.61	(142,642.59)	93.70
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	205,325.90	81,051.03	(124,274.87)	39.47
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	131,035.64	131,035.64	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	201,217.72	201,217.72	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	33	33		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16	16		
620001	Удирдах ажилтан	3	3		
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9		
620003	Үйлчлэх ажилтан	4	4		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	16	16		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2		
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	0	0		
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	0	0		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,908.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,908.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,288.3

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382.8
2104	Хангамж, бараа материалын зардал	905.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,619.9
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,619.9
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	29,619.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	56,908.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,908.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,831.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,077.1

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хушаат сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг **“Өрхийн өсөлтөөс-Хушаатын хөгжил”** гэж тодорхойлсон байна.

Дээрх дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Иргэдийн эрүүл энх, ая тухтай амьдрах, сурах, хөдөлмөрлөх боломжид суурилсан нийгмийн баталгааг бий болгоно.
- Эрүүл мэндийн бодлогыг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- Өрсөлдөх чадвартай, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.
- Биеийн тамир, спортыг дэмжих замаар хүний дундаж наслалтыг уртасган соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлнэ.
- Өрх бүр аж ахуй эрхлэхийг дэмжин ажилтай, орлоготой болгоно.
- Цаг уурын нөхцөлд дасан зохицсон газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, байгаль орчноо хамгаалан, эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулна.

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Худалдаа үйлчилгээний газруудыг орчин үеийн эрүүл ахуй, стандартын шаардлагыг хангуулж, үйлдвэрлэл үйлчилгээний төвийн тоог нэмэгдүүлнэ.
- Төсвийн ил тод байдал, сахилга батыг хангаж, төсвийн оновчтой хуваарилалт, зарцуулалтыг удирдан, иргэд олон нийтийн санхүү, төсвийн мэдлэгийг дээшлүүлнэ.
- Төрийн чадварлаг, ёс зүйтэй албыг төлөвшүүлж иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэн, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангана.
- Төрийн үйлчилгээнд ухаалаг тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан, хариуцлагатай, шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэнэ.
- Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх замаар иргэн бүр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэг төлөвшлийг бий болгож, иргэдийн эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмыг ханган аюулгүй амьдрах орчныг хангана.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

2024 онд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус сумын ХХС-ийн 2023-2024 оны үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийж 11 албан шаардлага, 9 зөвлөмж хүргүүлсэн бол ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хушаат сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хушаат сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан *“Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”*-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хушаат сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан *“Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 728,058.7 мянган төгрөгөөр буюу 40.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	195,041.8	480,165.6	285,123.8
Авлага	206,377.0	124,826.0	(81,551.0)
Бараа материал	174,144.6	169,696.8	(4,447.8)
Үндсэн хөрөнгө	1,231,862.4	1,760,796.2	528,933.8
Нийт хөрөнгө	1,807,425.8	2,535,484.6	728,058.8
Өр төлбөр	21,998.6	6,560.0	(15,438.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,785,427.2	2,528,924.6	743,497.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,807,425.8	2,535,484.6	728,058.8

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байгаа бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 480,165.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 285,123.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	195,041.8	480,165.6	285,123.8
Төгрөг	195,041.8	480,165.6	285,123.8
Төрийн сангийн харилцах	195,041.8	480,165.6	285,123.8
Арилжааны банк дахь харилцах			
Дүн	195,041.8	480,165.6	285,123.8

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 278,947.9 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 91,261.6 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 109,956.1 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 124,826.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 81,551.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	13,656.2	8,283.2	(5,373.0)
Байгууллагаас авах авлага			
Хувь хүмүүсээс авах авлага	29,940.2	29,440.2	(500.0)

Хувь хүмүүст олгосон зээл	162,780.6	87,102.6	(75,678.0)
Дүн	206,377.0	124,826.0	(81,551.0)

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- Хувь хүмүүсээс авах авлага буюу ЗДТГ-аас Мянганы сорилын сангийн дэмжлэгтэйгээр олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 29,440.2 мянган төгрөг,
- ХХС-ийн зээлийн 87,102.6 мянган төгрөгийн, зээлийн хүүгийн 8,283.2 мянган төгрөг зэрэг.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 169,696.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,447.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал			
Эм боох материал			
Бэлэн бүтээгдэхүүн			
Бичиг хэргийн материал	287.8	-	(287.8)
Аж ахуйн материал	640.0	560.0	(80.0)
Сэлбэг хэрэгсэл			
Барилгын засварын материал			
Хүнсний материал			
Бусад хангамжийн материал	173,216.8	169,136.8	(4,080.0)
Дүн	174,144.6	169,696.8	(4,447.8)

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 4,447.8 мянган төгрөгөөр буурч 169,696.8 мянган төгрөг болсон нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 631,646.8 мянган төгрөгийн материал худалдан авсан, БОАЖЯ-наас байгаль орчны улсын байцаагч, хамгаалагч нарт олгосон 1,394.40 мянган төгрөгийн дүрэмт хувцсыг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан, 156,473.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, ОНХС-аар хийгдсэн 481,015.10 мянган төгрөгийн ажлуудыг ашиглагч байгууллагуудад шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,760,796.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 528,933.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	500,869.0	500,114.8	(754.2)
Авто-тээврийн хэрэгсэл	76,766.2	185,022.5	108,256.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	152,195.0	526,391.5	374,196.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	10,857.8	33,619.3	22,761.5
Зам, гүүрийн байгууламж	58,961.6	51,150.8	(7,810.8)
Бусад үндсэн хөрөнгө	126,106.1	153,022.5	26,916.4
Дуусаагүй барилга, байгууламж	119,224.0	119,224.0	-
Ном	70,000.0	70,000.0	-
Бусад биет бус хөрөнгө	116,882.8	122,250.8	5,368.0
НИЙТ ДҮН	1,231,862.5	1,760,796.2	528,933.7

Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,760,796.2 мянган төгрөг болж өмнөх оноос 528,933.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 48,458.00 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 619,080.90 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, ЗДТГ-т бүртгэлтэй 2 ширхэг газрыг 5,368.00 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэн, ИТХ-ын 512.8 мянган төгрөгийн эд хогшлыг акталж, тайлант хугацаанд 143,973.1 мянган төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 6,560.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,438.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	21,998.7	6,560.0	(15,438.7)
Дүн	21,998.7	6,560.0	(15,438.7)

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэлд ХХС-ийн 2012 оны 4,960.0 мянган төгрөгийн өглөг, ОНХС-ийн 2022 оны төлөвлөсөн гэрэлтүүлгийн дуусаагүй ажлын хөлс 1,600.0 мянган төгрөгийн өглөг тус тус тайлагнагдсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,528,924.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 743,497.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	310,470.4	310,470.4	-
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан			
Өмнөх үеийн үр дүн	1,150,629.6	1,314,401.0	163,771.3

Тайлант үеийн үр дүн	163,771.3	743,497.4	579,726.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,555.8	160,555.8	
Дүн	1,785,427.2	2,528,924.6	743,497.4

Эх сурвалж: Хушаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 743,497.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Хушаат сумын ИТХ-ын “2024 оны тодотгосон төсвийг батлах тухай” 2024 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор татварын орлогыг 561,414.8 мянган төгрөгөөр, татварын бус орлогыг 46,940.3 мянган төгрөгөөр, нийт 608,355.1 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 810,893.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 202,538.4 мянган төгрөгөөр буюу 29.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	561,414.8	753,416.5	192,001.7	131.2
Үйл ажиллагааны орлого	77,476.1	103,474.7	25,998.6	133.6
Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	224,940.6	307,734.5	82,793.9	136.8
Хөрөнгийн орлого	6,100.5	12,159.7	6,059.2	199.3
Хөрөнгө борлуулсны орлого	4,085.0	7,659.5	3,574.5	187.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	6,401.5	8,699.1	2,297.6	135.9
Бууны албан татвар	1,406.0	1,526.0	120.0	108.5
Малд ногдуулах албан татвар	159,146.7	219,334.4	60,187.7	137.8
Улсын тэмдэгтийн хураамж	5,633.2	6,259.3	626.1	111.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	765.0	800.0	35.0	104.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,817.4	5,853.4	36.0	100.6
Газрын төлбөр	41,173.9	45,896.7	4,722.8	111.5

Дуудлага худалдаа	41,641.6	45,402.3	3,760.7	109.0
Ойн нөөц ашигласны төлбөр	4,476.9	5,343.9	867.0	119.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	869.0	1,774.0	905.0	204.1
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	8,417.3	8,434.9	17.6	100.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(26,935.9)	(26,935.9)	-	100.0
Татварын бус орлого	46,940.3	57,477.0	10,536.7	127.2
Торгуулийн орлого	33,736.9	42,913.7	9,176.8	127.2
Бусад орлого	13,203.4	14,563.3	1,359.9	110.3
Нийт орлогын дүн	608,355.1	810,893.5	202,538.4	129.2

Эх сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төлөвлөсөн татварын болон татварын бус орлого бүх нэр төрлөөр давж биелсэн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Үйл ажиллагааны орлого:** ЭТТ хувьцаат компанийн 2024 оны ногдол ашгаас суутгасан орлогын албан татвар төрийн санд шилжин үйл ажиллагааны орлого 103,474.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй 33.6 хувьтай давж биелсэн,
- **Цалин хөлс түүнтэй адилтгах орлого:** 82,793.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2024 оны 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан,
- **Хөрөнгийн орлого:** 6,059.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд иргэдийн хадгаламж, хүүхдийн мөнгөний хадгаламж өссөнөөр тухайн орлого 99.3 хувиар давж биелсэн,
- **Малын тоо толгойн албан татвар:** Өмнөх оны татварын өрийг барагдуулж тайлант оны ногдлыг төлүүлэн шат дараалсан арга хэмжээ авч ажилласнаар өссөн дүнгээр биелсэн,
- **Хүү торгуулийн орлого:** Тайлант онд тус сумын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Татварын хяналт шалгалт хийгдэж, татварын тооцоотой ААН-д алданги тооцож оруулснаас шалтгаалан орлого 9,176.8 мянган төгрөгөөр буюу 27.2 хувиар давж биелсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 1,241,170.7 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 503,330.1 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг **1,744,500.8** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 531,194.2 мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 1,126,970.4 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 394,520.5 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 57,876.1 мянган төгрөг, ХХС-ийн орлогоос 199,198.7 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс 101,980.5 мянган зэрэг нийт **2,411,740.4** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг **58,584.7** мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, **2,470,325.1** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

Эх үүсвэрийн өөрчлөлт:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 77,160.9 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 17,084.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 35,660.9 мянган төгрөгөөр бууруулан

Төсвийн зарлагын өөрчлөлт:

- ОНХС-г 17,084.7 мянган төгрөгөөр, ,
- ЗДТГ-ын урсгал зардлыг 41,500. мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр **2,470,325.1** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,612,090.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 672,732.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэн төлөгдөх зээлд 185,502.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	172,028.7	152,180.1	19,848.6	88.5%
2	Засаг даргын тамгын газар	1,061,016.2	977,898.8	83,117.4	92.2%
3	Орон нутгийн хөгжлийн сан	672,732.4	641,658.5	31,073.9	95.4%
4	Хоршоо хөгжүүлэх сан	199,198.7	150.0	199,048.7	0.1%
5	ЕБС	211,144.7	211,144.7	-	100.0%
6	Эрүүл мэндийн төв	48,981.0	47,703.3	1,277.7	97.4%
7	Цэцэрлэг	56,616.7	54,499.1	2,117.6	96.3%
8	Соёлын төв	48,606.7	47,990.0	616.7	98.7%
	Нийт дүн	2,470,325.1	2,133,224.5	337,100.6	83.6%

сурвалж: Хушаат сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 1,091,309.5 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 810,893.5 мянган төгрөг, ОНХС-аас 411,605.2 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 181,787.8 мянган төгрөг зэрэг нийт **2,495,596.0** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж **2,133,224.5** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,133,224.5 мянган төгрөг буюу 86.3 хувьтай байгаа нь урсгал зардлыг 120,523.2 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 31,073.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал:

- *цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 67,066.9 мянган төгрөгөөр,*
- *байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,011.4 мянган төгрөгөөр,*
- *хангамж бараа материалын зардал 0.6 мянган төгрөгөөр,*
- *эд хогшил, урсгал засварын зардал 305.8 мянган төгрөгөөр,*
- *томилолт, зочны зардал 3,349.0 мянган төгрөгөөр,*
- *бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 23,279.1 мянган төгрөгөөр,*
- *урсгал шилжүүлэг 1,238.9 мянган төгрөг,*
- *бараа үйлчилгээний бусад зардал 13,578.2 мянган төгрөгөөр зэрэг нийт 112,829.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.*

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 23 төсөл, арга хэмжээнд 672,732.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 641,658.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 31,073.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 56,908.2 мянган төгрөгийн дараах орлогуудыг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- *Татан төвлөрүүлэлт(урьд оны зураг төсвийн барьцаа төлбөр) 25,130.0 мянган төгрөг,*
- *ухаалаг худгийн карт цэнэглэлт 238.3 мянган төгрөг,*
- *үзэсгэлэн худалдааны орлого 368.8 мянган төгрөг,*
- *тендерийн баримт бичиг худалдсаны үнэ 840.0 мянган төгрөг,*
- *Мянганы сорилтын сангийн зээлийн эргэн төлөлт 500.0 мянган төгрөг,*
- *хашаа хайс акталж зарсны төлбөр 1,000.0 мянган төгрөг,*

- Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 875.1 мянган төгрөг,
- Аймгийн ЗДНХ-өөс ЕБС-ийн дээврийн засварын зардалд 24,956.0 мянган төгрөг,
- Тэргүүний сумын урамшуулал 3,000.0 мянган төгрөг,

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 382.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 905.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 3,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 23,000.0 мянган төгрөг зэрэг нийт 27,288.3 мянган төгрөгийг зарцуулан, **29,619.9** мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Үүнээс					
	Тоо	дүн	ШХА		Харьцуулалтын арга		НТШ	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Сумын ОНХС	23	672,732.4	16	187,084.7	7	485,647.7	-	-

: Хушаат сумын ТТЗ-ийн ХА ажиллагааны төлөвлөгөө, тайлан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хушаат сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан км, спидометрийн заалтыг бүрэн бүртгэж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Энхбүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хушаат сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 1,403,291.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,032.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус сум нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлсэн,*
- *Тээврийн хэрэгслүүдийг ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар хангасан,*
- *Зайлшгүй шаардлагатай зардлаас бусад зардлыг танасан зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр зардлуудыг хэмнэж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтыг зөрчин сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн ЗДТГ-ын батлагдсан төсвөөс цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зургийг хадгалан үлдээх зорилгоор **3,377.4** мянган төгрөгийг шилжүүлсэн боловч хүлээж аваагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	171	171		
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	171		
3	Засаг даргын Тамгын газар	171	171		
	Нийт дүн	513	513		

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

Тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн дүнгээр нийт 513 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

4.4.2 Худалдан авах ажиллагаа

ЗДТГ нь тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, батлуулж, тайлагнасан боловч шууд худалдан авах босго үнээс давсан **28,731.1** мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр НИК ХХК-иас худалдан авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь “... нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, Засгийн

газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар - Бараа 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 85.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,208.9	1	4,208.9	100.0
Албан шаардлага	2	47,648.1	1	38,921.7	66.7
Зөвлөмж	1	9,711.5	1	9,711.5	100.0
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1		1	-	100.0
Нийт дүн	5	61,568.5	4	52,842.1	85.8

Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг давтан гаргасан ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Цогбаяр, нягтлан бодогч Б.Мөнхзул нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1.Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг уг аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн” болон

“ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ:

Аудитаар нийт **3,428,114.8** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 3,421,502.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,612.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдааг залруулах зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны устгалыг татаагүйгээс санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн нийт **3,421,502.8** мянган төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого, зарлагыг тус бүр 1,710,751.4 мянган төгрөгөөр илүү,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлого, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг тус бүр 1,710,751.4 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Залруулаагүй алдаа:

- ЗДТГ нь хөрөнгөд бүртгэлтэй 3,000.0 мянган төгрөгийн хүлэмж, 3,612.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерт 2023 оноос хойш элэгдэл тооцоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгүүдэд элэгдэл тооцож 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **11,659.9** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 10,111.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1,548.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

ЗДТГ:

1. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс ЗДТГ нь төрийн өмчийн барилгын тогтмол зардлын арга хэмжээний урсгал засварын зардлын батлагдсан төсвөөс байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлыг санхүүжүүлж **5,826.3** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Цогбаяр, нягтлан бодогч Б.Мөнхзул нарт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүй улмаас орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварын **2,285.5** мянган төгрөгийг суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүй өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ, 20.2.5: ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өр төлбөр үүсгэхгүй ажиллах, өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

3.ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс Хүдэр сумын харьяат Монгол Улсын начин Д.Төрболдын цолны мялаалгад **2,000.0** мянган төгрөгийн хандив өгч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, гэсэн заалт болон Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1-2.1.6 дугаар заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын дагуу сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/21 дүгээр захирамжаар ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Цогбаярт “ганцаарчилсан хэлбэрээр сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан боловч 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Б/22 дугаар захирамжаар уг сахилгын шийтгэл ногдуулах захирамжийг хүчингүй болгосон буюу төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь “Сахилгын зөрчлийг **илрүүлснээс хойш 6 сар**, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй”, 48.7 дахь “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш **1 жилийн дотор** сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх "...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсэн заалтын дагуу сумын Засаг дарга Н.Захирахбаатарт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг** аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ: Тайлант онд зарцуулсан 1,548.1 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан км, спидометрийн заалтыг бүрэн бүртгээгүй, автомашины 100 км-т зарцуулах шатахууны нормыг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар "Маягт заавар батлах тухай" тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан км, спидометрийн заалтыг бүрэн бүртгэж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	3,421,502.8					1	3,421,502.8				
ЗДТГ	1	6,612.0							1	6,612.0	1	6,612.0
Дүн	2	3,424,880.2					1	3,421,502.8	1	6,612.0	1	6,612.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	4	9,659.9			2	8,111.8	1	1,548.1	1	3		
ТТЗ	1	2,000.0			1	2,000.0						
Дүн	5	11,659.9			3	10,111.8	1	1,548.1	1	3		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилттэй холбоотой												
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	28,731.1					1	28,731.1				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой												
Түүх соёлын дурсгалт газар,	1	3,377.4					1	3,377.4				

байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулгасан								
Дүн	2	32,108.5			2	32,108.5		
Нийт дүн	2	32,108.5			2	32,108.5		